



I–XII/2021


Тархаасан: 2022 оны 01 дүгээр сарын 16



## Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 8.6 хувиар буурлаа

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 онд урьдчилсан гүйцэтгэлээр 18.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.8 (10.7%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 692.8 (5.9%) тэрбум төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 883.8 (24.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн цахилгаан хий, уур, агааржуулалтын салбарын үйлдвэрлэл 168.9 (14.1%) тэрбум төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэл 39.0 (29.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 2021 оны 12 дугаар сард 1.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 138.9 (8.6%) тэрбум төгрөгөөр буурлаа. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 147.6 (14.1%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны 12 дугаар сард 896.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 429.5 (32.4%) тэрбум төгрөгөөр буурахад нүүрс олборлолт 398.8 (71.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 2021 онд урьдчилсан гүйцэтгэлээр зэсийн баяжмал, хүрэн нүүрс, газрын тос олборлолт өмнөх оны мөн үеэс 3.9 – 13.7 хувь, боловсруулах

аж үйлдвэрийн салбарт гар ариутгагч, малын мах, катодын зэс (99%), ус, ундаа, жүүс, спирт, цемент, согтууруулах ундаа, боловсруулсан шингэн сүү, нүүрсэн шахмал түлш, баяжуулсан нүүрс, шохой, янжуур тамхи, металл бэлдэц зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.2 хувиас 2.3 дахин өссөн байна.

#### ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2020		2021*		2021* I-XII
		XII	I-XII	XII	I-XII	2020 I-XII
						хувь
<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>						
Чулуун нүүрс	мян.т	5 284.8	36 263.9	1 449.8	22 707.7	62.6
Хүрэн нүүрс	мян.т	835.6	6 599.8	1 024.8	7 416.6	112.4
Газрын тос	мян.баррел	543.4	4 105.9	33.6	4 667.1	113.7
Зэсийн баяжмал, металл агуулгаараа	мян.т	113.8	1 276.7	103.2	1 326.3	103.9
Цэвэршүүлээгүй алт	кг	1 459.2	20 225.5	1 118.4	19 054.4	94.2
Төмрийн хүдэр	мян.т	506.2	9 224.4	553.0	9 171.9	99.4
Хайлуур жонш	мян.т	9.1	127.3	8.7	118.3	92.9
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>						
Малын мах	т	3 928.9	25 580.2	2 828.0	26 060.8	101.9
Шингэн сүү	мян.л	4 809.9	45 045.4	5 136.5	53 614.4	119.0
Гурил	т	27 737.1	235 114.1	23 389.3	217 891.2	92.7
Цэвэр спирт	мян.л	375.2	10 063.7	1 133.8	10 947.0	108.8
Согтууруулах ундаа	сая л	7.0	117.4	8.7	129.2	110.0
Ус, ундаа, жүүс	сая л	22.1	319.4	26.4	331.1	103.7
Янжуур тамхи	мян.блок	248.7	2 007.5	581.2	3 926.4	195.6
Амны хаалт	мян.ш	2 098.9	15 711.0	1 579.9	11 223.5	71.4
Гар ариутгагч	мян.л	20.6	329.6	18.4	330.3	100.2
Ноолууран сүлжмэл эдлэл	мян.ш	66.7	1 360.9	66.1	523.9	38.5
Самнасан ноолуур	т	25.3	516.4	37.9	511.7	99.1
Баяжуулсан нүүрс	мян.т	406.2	2 860.1	39.0	3 815.0	133.4
Нүүрсэн шахмал түлш	мян.т	116.9	553.9	95.9	729.8	131.7
Цемент	мян.т	0.5	1 182.2	40.1	1 293.3	109.4
Шохой	т	3 122.3	70 164.3	9 844.3	93 625.0	133.4
Катодын зэс, 99%	т	920.5	9 488.3	1 007.9	9 689.9	102.1
Металл бэлдэц	т	5.1	15 286.3	2 842.5	35 917.1	2.3 <sup>1</sup>

<sup>1</sup> Дахин их

Харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт төмрийн хүдэр, алт, хайлуур жонш, чулуун нүүрсний олборлолт 0.6 – 37.4 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарт самнасан ноолуур, гурил, амны хаалт, ноолууран сүлжмэл эдлэл зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.9 – 61.5 хувиар буурсан байна.


Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 24.8 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.9 (24.5%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 4.0 (29.3%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

Салбар	2020		2021*			2021* I-XII
	XII	I-XII	XII	I-XII	гадаадад	2020 I-XII
	тэрбум төгрөг					хувь
<b>Нийт дүн</b>	<b>2 303.9</b>	<b>19 934.0</b>	<b>1 637.3</b>	<b>24 825.0</b>	<b>15 478.5</b>	<b>124.5</b>
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1 714.1	13 573.2	985.9	17 549.2	14 226.4	129.3
Боловсруулах аж үйлдвэр	442.1	5 014.2	469.6	5 730.2	1 252.1	114.3
Цахилгаан хий, уур, агааржуулалт	130.3	1 206.0	161.7	1 369.0	-	113.5
Ус хангамж, сувагжилтын систем	17.4	140.7	20.1	176.6	-	125.6

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оноос 4.0 (29.3%) их наяд төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 4.1 (46.4%) их наяд төгрөгөөр, газрын тос олборлолтын салбарынх 277.0 (65.3%) тэрбум төгрөгөөр, бусад ашигт малтмал олборлолтын салбарынх 53.5 (19.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

ЗУРАГ 2. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, тэрбум төгрөг



Гадаад зах зээлд 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15.5 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн бөгөөд уул уурхайн бүтээгдэхүүний 72.3 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 21.4 хувийг нүүрс олборлолтын салбар, 4.9 хувийг газрын тос олборлолтын салбар, 1.4 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж, газрын тос олборлолтын салбар өмнөх оноос 0.7 нэгж хувиар, металлын хүдэр олборлолтын салбар 12.1 нэгж хувиар тус тус өсөж, нүүрс олборлолтын салбар 12.4 нэгж хувиар, бусад ашигт малтмал олборлолтын салбар 0.4 нэгж хувиар тус тус буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс (улирлын нөлөөллийг арилгасан тооцоо) 2021 оны 12 дугаар сард 187.4 (2015=100) болж, өмнөх оны мөн үеэс 40.5 хувиар өссөн байна.

## Ойлголт, тодорхойлолт

**Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл:** Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн:** Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

**Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн (биет хэмжээний) индекс:** Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейрсийн биет хэмжээний индексийн томъёог ашиглан тооцно.

## Тооцох аргачлал:

Ласпейрсийн биет хэмжээний индексийн томъёо:

$$I_{LQ} = \frac{\sum (Q_t \cdot P_0)}{\sum (Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum \left( \frac{Q_t}{Q_0} \right) \cdot W_0 \cdot 100$$

Q<sub>t</sub>- Бүтээгдэхүүний тайлант үеийн биет хэмжээ

Q<sub>0</sub>- Бүтээгдэхүүний суурь үеийн биет хэмжээ

P<sub>0</sub>- Бүтээгдэхүүний суурь үеийн үнэ

W<sub>0</sub>- Жин



## **Тайлбар:**

ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

## **Эх үүсвэр:**

ҮСХ, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

## **Ангилал, код:**

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал

## **Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

## **Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2022 оны 2 дугаар сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын

дарга А.Дэмбэрэл

Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын

статистикч Б.Энхболд,

статистикч Г.Цэвэлмаа

Утас: (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212